



МОНГОЛЫН
ХӨРӨНГИЙН
БИРЖ

2020 *Э-сонин*

3-Р САР

80-р дугаар





ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ

Зах зээлийн тойм

/2020.03.31-ний өдрийн байдлаар/

1. Арилжаа явагдсан өдөр

2. Нийт арилжааны үнийн дүн /төгрөг/

Хувьцаа /анхдагч/

Хувьцаа /хоёрдогч/

Засгийн газрын үнэт цаас /хоёрдогч/

Компанийн бонд /анхдагч/

Компанийн бонд /хоёрдогч/

3. Нийт арилжигдсан үнэт цаасны тоо ширхэг

Хувьцаа /анхдагч/

Хувьцаа /хоёрдогч/


Засгийн газрын үнэт цаас /хоёрдогч/

Компанийн бонд /анхдагч/


Компанийн бонд /хоёрдогч/

4. Нийт хийгдсэн хэлцлийн тоо


Зах зээлийн үнэлгээ




TOP-20 индекс



MSE A индекс



MSE B индекс



Бүртгэлтэй хувьцаат компани

1. Нийт компанийн тоо	198
100% төрийн өмчит	18
Төрийн өмчийн оролцоотой	10
Хувийн өмчийн	170
I ангилал	14
II ангилал	44
III ангилал	140

Гишүүн үнэт цаасны компани

1. Гишүүн Үнэт цаасны компанийн тоо	54
Үүнээс: Брокер, Дилер	54
Андеррайтер	19
Хөрөнгө оруулалтын зөвлөх	14



Арилжаанд идэвхтэй оролцсон гишүүн үнэт цаасны компаниуд

/2020.03.31-ний байдлаар/

	Нэр	Үнэт цаас авсан		Үнэт цаас зарсан		Арилжааны дүн / авсан, зарсан/ (₮)
		Тоо ширхэг	Үнийн дүн (₮)	Тоо ширхэг	Үнийн дүн (₮)	
1	Ард секюритиз УЦК ХХК	2,412,625	1,261,253,959	2,098,977	1,186,482,054	2,447,736,013
2	БиДиСек УЦК ХК	639,654	217,305,839	2,458,111	839,047,903	1,056,353,742
3	Инвескор капитал УЦК ХХК	170,152	428,176,709	152,301	386,251,328	814,428,037
4	Евразиа капитал монголиа УЦК ХХК	2,095,891	628,767,300	11	13,250	628,780,550
5	Ти Ди Би Капитал УЦК ХХК	681,331	151,806,033	701,798	110,330,768	262,136,801
6	Стандарт инвестмент УЦК ХХК	646,096	84,052,320	1,126,873	163,303,946	247,356,266
7	Эс Жи Капитал УЦК ХХК	504,082	63,817,216	751,582	100,798,918	164,616,133
8	Голомт Капитал УЦК ХХК	426,323	41,994,059	1,158,907	94,557,242	136,551,301
9	Апекс Капитал УЦК ХХК	338,904	41,535,542	248,992	76,992,214	118,527,756
10	Новел инвестмент УЦК ХХК	77,029	76,232,611	125,251	32,819,363	109,051,974
11	Дархан брокер УЦК ХХК	13,541	50,651,135	15,373	50,578,130	101,229,264
12	Масдак УЦК ХХК	245,460	48,670,204	245,766	49,261,164	97,931,367
13	Монсек УЦК ХХК	160,684	12,115,106	271,635	60,145,422	72,260,528
14	Бумбат-Алтай УЦК ХХК	200,588	21,336,857	280,377	45,876,648	67,213,505
15	Централ секьюритийз УЦК ХХК	185,111	29,217,794	35,510	11,073,033	40,290,826
16	Гацуурт трейд УЦК ХХК	239,253	39,411,608	10	642,500	40,054,108
17	Гранддевелопмент УЦК ХХК	170,823	20,521,584	180,046	18,994,607	39,516,190
18	Сикап УЦК ХХК	482,867	33,113,496	2,301	67,159	33,180,655
19	Зэргэд УЦК ХХК	41,877	18,578,520	37,747	14,484,230	33,062,750
20	Дэлгэрхангай секюритиз УЦК ХХК	12,753	12,325,533	45,717	20,605,245	32,930,778

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

/2020.03.31-ний байдлаар/

№	Сим-бол	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /₮/	Дээд Ханш	Доод Ханш	Өөрчлөлт %/
1	AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	493,111	742,507,070	1,600	1,253	1.13
2	MDR	ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП	2,097,335	629,272,860	402	300	-2.86
3	INV	ИНВЕСКОР ББСБ	175,838	446,750,606	2,670	2,400	-6.02
4	MNP	МОНГОЛ ШУУДАН	570,740	349,218,515	700	599	7.20
5	APU	АПУ	471,945	273,284,422	650	500	-17.14
6	GOV	ГОВЬ	541,251	110,681,555	245	160	-28.46
7	AMT	ХАР ХОРУМ ПРОПЕРТИЙС	750,582	100,658,525	186	90	138.21
8	ADB	АРД КРЕДИТ ББСБ	1,105,909	80,910,005	80	65	5.93
9	UID	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	57,768	80,115,922	1,499	1,043	-17.15
10	TTL	ТАВАН ТОЛГОЙ	10,641	69,135,415	6,750	6,250	-5.45
11	AIC	АРД ДААТГАЛ	79,025	55,896,169	738	630	1.41
12	ERS	МОНГОЛ АЛТ	8,755	48,152,550	5,550	5,500	-15.38
13	DBL	ДАВААНБУЛАГ	244,190	48,019,964	197	197	0.00
14	MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	1,009,309	47,811,799	52	44	-11.26
15	LEND	ЛЭНДМН ББСБ	1,368,766	44,254,444	40	28.02	-25.05
16	MFC	МОНОС ХҮНС	642,285	44,085,383	73.5	66.7	-5.02
17	SUL	ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ	441	31,178,800	88,000	55,100	-29.38
18	ERDN	ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЙШН	56,048	27,986,976	550	470	-9.07
19	TUM	ТҮМЭН ШУВУУТ	164,560	24,775,093	160	132	-11.88
20	MMX	МАХИМПЕКС	7,622	19,600,991	3,100	2,350	1.02



Ханшийн өсөлттэй хувьцаа

/2020.03.31-ний байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан /Ширхэг/	Хаалтын ханш		Ханшийн өөрчлөлт /₮/	Өөрчлөлт %/
			2020-02-28	2020-03-31		
1	ХАР ХОРУМ ПРОПЕРТИЙС	750,582	78.00	185.80	107.80	138.21
2	МОНГОЛ ДААТГАЛ	56	900.00	1,500.00	600.00	66.67
3	ГУТАЛ	836	15,250.00	20,400.00	5,150.00	33.77
4	УВС ЧАЦАРГАНА	4	240.00	300.00	60.00	25.00
5	ТЕХНИК ИМПОРТ	74	7,500.00	9,345.00	1,845.00	24.60
6	ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ	131	4,879.00	5,700.00	821.00	16.83
7	ИНГЭТТОЛГОЙ	1	158.70	182.50	23.80	15.00
8	ХАЙ БИ ОЙЛ	503	55.00	62.99	7.99	14.53
9	ХӨХ ГАН	690	70.00	79.50	9.50	13.57
10	ТҮШИГ УУЛ	12,606	544.77	600.00	55.23	10.14
11	БАГАНУУР	262	910.00	993.00	83.00	9.12
12	МОНГОЛ ШУУДАН	570,740	625.00	670.00	45.00	7.20
13	УБ-БҮК	340	370.00	396.00	26.00	7.03
14	ХЭРЛЭН ХИВС	609	39.00	41.40	2.40	6.15
15	АРД КРЕДИТ ББСБ	1,105,909	74.98	79.43	4.45	5.93
16	МОНИНЖБАР	4	120.00	126.00	6.00	5.00
17	ОЛЛОО	2	69.30	72.69	3.39	4.89
18	ТЭЭВЭР ДАРХАН	301	7,800.00	8,150.00	350.00	4.49
19	СТАНДАРТ АГРИКАЛЧЕР ГРУПП	1	77.00	80.00	3.00	3.90
20	УЛААНСАН	1	800.00	830.00	30.00	3.75

Ханшийн бууралттай хувьцаа

/2020.03.31-ний байдлаар/

№	Үнэт цаас нэр	Арилжигдсан /Ширхэг/	Хаалтын ханш (₮)		Ханшийн өөрчлөлт (₮)	Өөрчлөлт %
			2020-02-28	2020-03-31		
1	ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ	441	88,000.00	62,150.00	-25,850.00	-29.38
2	ГОВЬ	541,251	242.90	173.78	-69.12	-28.46
3	ЛЭНДМН ББСБ	1,368,766	40.00	29.98	-10.02	-25.05
4	РЕМИКОН	69,448	29.94	24.00	-5.94	-19.84
5	МИК ХОЛДИНГ	4	14,800.00	11,910.00	-2,890.00	-19.53
6	БӨХӨГ	73	1,850.00	1,500.00	-350.00	-18.92
7	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	57,768	1,300.00	1,077.00	-223.00	-17.15
8	АПУ	471,945	644.01	533.64	-110.37	-17.14
9	ДАРХАН НЭХИЙ	189	15,790.00	13,200.00	-2,590.00	-16.40
10	ШИВЭЭ ОВОО	388	2,300.00	1,925.00	-375.00	-16.30
11	МОНГОЛ АЛТ	8,755	6,500.00	5,500.00	-1,000.00	-15.38
12	АВТО ИМПЕКС	1	2,300.00	1,960.00	-340.00	-14.78
13	БЛЮСКАЙ СЕКЬЮРИТИЗ	5	1,700.00	1,450.00	-250.00	-14.71
14	МОГОЙН ГОЛ	32	9,000.00	7,700.00	-1,300.00	-14.44
15	МОНГОЛ БАЗАЛТ	64,271	244.00	209.47	-34.53	-14.15



ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТУЛГАМДСАН АСУУДЛУУДЫГ ХАМТРАН ШИЙДВЭРЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ЗАХ ЗЭЭЛИЙН НИЙТ ОРОЛЦОГЧДОД УРИАЛГА ГАРГАЖ БАЙНА

1990-ээд онд эхэлсэн ардчилал, шинэчлэлийн түүхэн үед “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК /МХБ/-ээр 475 улсын үйлдвэрийн газрын хувьцааг цэнхэр, ягаан тасалбараар 1.2 сая иргэнд эзэмшүүлж хувьчилснаар Монгол Улсад орчин үеийн зах зээлийн эдийн засгийн үндэс суурь тавигдаж байсан билээ. МХБ нь энэхүү түүхэн үүргээ амжилттай гүйцэтгэхийн сацуу өнөөг хүртэл 40 гаруй аж ахуйн нэгжид 187.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг хөрөнгийн зах зээлээс татан төвлөрүүлэхэд зуучлан, нийт 3.3 их наяд төгрөгийн үнийн дүн бүхий үнэт цаасны арилжаа зохион байгуулаад байна.

Монгол Улсын Засгийн газрын шийдвэрийн дагуу МХБ нь олон улсад нэр хүнд бүхий Лондонгийн хөрөнгийн бирж групптэй стратегийн түвшинд хамтран ажиллаж, хөрөнгийн зах зээлийн зохицуулалт, техник, технологи, дэд бүтцийг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлсэн билээ. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийг 2013 онд шинэчлэн найруулахад МХБ-ийн зүгээс чухал үүрэгтэйгээр оролцож, үнэт цаасны зах зээлийн хууль эрх зүйн орчныг олон улсын жишигт нийцүүлэн шинэчилсний үр дүнд гадаад улсын компанийн үнэт цаасны давхар бүртгэл, хадгаламжийн бичиг, төлбөр тооцооны дараа төлбөрт систем, үнэт цаасны номиналь болон бенефициар өмчлөл, кастодианы үйлчилгээ зэрэг олон шинэ концепциуд зах зээлд шинээр нэвтэрсэн юм. Ингэснээр 2018 онд гадаад улсын компанийн үнэт цаасыг анх удаа МХБ дээр давхар бүртгэж арилжаалсан, арилжааны үнийн дүн хамгийн дээд хэмжээндээ хүрсэн, 2019 онд анхдагч зах зээлээс татан төвлөрүүлсэн хөрөнгийн дүн дээд амжилтаа тогтоосон зэргээр хөрөнгийн зах зээл сүүлийн жилүүдэд урьд өмнө байгаагүйгээр идэвхжиж, чамлахааргүй их амжилтанд хүрч байна. Түүнчлэн, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх болон хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг хөрөнгийн биржээр арилжаалах зохицуулалтыг цоо шинээр бүрдүүлж, хувьцаат компаниудын үүргийн хэрэгжилтийг сайжруулж хариуцлагажуулах, төлбөр тооцооны дараа төлбөрт Т+2 горимд нэвтрүүлэх чиглэлд зах зээлийн бусад оролцогчдын хамт бид ажиллаж байна.

Ийнхүү дотоодын хөрөнгийн зах зээлд тасралтгүй ахиц дэвшил гарч байгаа хэдий ч цаашид Монгол Улсын эдийн засгийн хөгжилд дорвитой хувь нэмэр оруулах, зах зээлийг үсрэнгүй хөгжүүлж, цоо шинэ түвшинд хүргэхийн тулд үнэт цаасны зах зээлийн бүх оролцогч байгууллагууд хамтран дараах хэд хэдэн нэн чухал арга хэмжээг авч хэрэгжүүлж ажиллахыг МХБ-ийн зүгээс нийт зах зээлийн оролцогч байгууллагуудад УРИАЛЖ байна. Үүнд:

1. Мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг бий болгох

Хөрөнгийн зах зээлд урт хугацааны хөрөнгийн эх үүсвэрийг бий болгох, шинээр гаргасан үнэт цаасанд хөрөнгө оруулах эрэлт тасралтгүй бий болгох, хувьцааны ханш тогтвортой байх, түүнчлэн компаниудын үнэт цаас гаргах сонирхлыг нэмэгдүүлэхэд мэргэжлийн хөрөнгө оруулагчдын оролцоо шийдвэрлэх ач холбогдолтой байдаг. Иймд дотоодын хөрөнгө оруулалтын сангуудыг идэвхжүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтын сангуудыг татан оролцуулах, мөн өнөөгийн тэтгэврийн тогтолцооны шинэчлэлийг хамтран хийснээр тэтгэврийн сангуудыг бий болгож, хөрөнгийн зах зээлд оролцох боломжийг нээн, иргэдийг хуримтлалтай болгож ирээдүйг нь баталгаажуулах.

2. Бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр, төрлийг нэмэгдүүлэх

Дотоодын эдийн засагт гадаад валютын урсгалыг нэмэгдүүлэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад томоохон дарамт болдог төгрөгийн ханшийн эрсдэлээс хамгаалах ач холбогдол бүхий гадаад валютын үнэт цаасыг нэвтрүүлэх, түүнчлэн жишиг хүүгийн муруйг бий болгох, хөрөнгө оруулалтын багцыг оновчтой бүрдүүлэхэд онцгой ач холбогдол бүхий эрсдэлгүй үнэт цаасны арилжааг хөрөнгийн зах зээлээр дамжуулан зохион байгуулах ажиллагааг дахин эхлүүлэх.

3. Хөрөнгийн зах зээлд татварын бодлогын дэмжлэг бий болгох

Хөрөнгийн зах зээлээ амжилттай хөгжүүлсэн улс орнуудын хөгжлийн туршлагаас үзэхэд зах зээлийн хөгжлийн эхэн үед төр засгаас татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн урт хугацааны бодлогыг хэрэгжүүлж ирсэн байдаг хэдий ч одоогийн байдлаар манай зах зээлд аливаа татварын хөнгөлөлт, чөлөөлөлт дутмаг байна.



Иймд хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулснаас олох аливаа орлогыг тодорхой хугацаанд чөлөөлөх, хувьцаагаа олон нийтэд санал болгосон компаниудад татварын хөнгөлөлт үзүүлэх зэргээр бодлогын дэмжлэгийг бий болгох нь зах зээлийг идэвхжүүлэхэд онцгой ач холбогдолтой юм.

4. Хөрөнгийн зах зээлийн өртөг зардлыг бууруулах

Манай хөрөнгийн зах зээлийн арилжааны шимтгэл нь бусад зах зээлүүдтэй харьцуулахад өндөр байдаг нь зах зээлд хөрөнгө оруулах сонирхлыг бууруулах, өдрийн арилжаа /day trade/ зэрэг их давтамжтай арилжаанаас ашиг олох боломжийг хязгаарладаг. Арилжааны шимтгэл нь үнэт цаасны компаниуд, хөрөнгийн бирж, арилжааны төлбөр тооцооны байгууллага, зохицуулагч байгууллага зэрэг олон байгууллагуудын шимтгэл хураамжаас бүрддэг тул өртөг зардлыг бууруулахын тулд олон улсын стандартын дагуу зах зээлийн нэгдмэл, оновчтой бүтэц, зохион байгуулалтыг бий болгох.

5. Иргэдийн хөрөнгийн зах зээлийн оролцоог нэмэгдүүлэх

Хуримтлагдсан ногдол ашгийг тараах

Монгол Улсын иргэд 1990-ээд оноос цэнхэр, ягаан тасалбарын өмч хувьчлалаар хөрөнгийн зах зээлтэй олон жилийн туршид холбогдсон байдаг. Гэвч зарим иргэд өөрсдийн хувьцаа эзэмшил болон ногдол ашиг тараагдсан эсэх талаар мэдээллээр хангагдаж чадахгүй байгаагаас их хэмжээний ногдол ашиг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХХК-д хуримтлагдан хадгалагдаж байдаг. Иймд энэхүү тараагдаагүй ногдол ашгийг эзэнжүүлж тараах ажлыг зах зээлийн хэмжээнд зохион байгуулж, ард иргэд хөрөнгийн зах зээлийн ашиг шимийг бодитоор хүртэж, цаашид улам идэвхтэй оролцох боломж бүрдүүлэх.

“Эрдэнэс тавантолгой” ХК-ийн хувьцааг хөрөнгийн биржээр арилжаалах

Монгол Улсын иргэн бүрт 2012 онд эзэмшүүлсэн “Эрдэнэс тавантолгой” ХК нь одоогийн байдлаар хөрөнгийн биржид бүртгэгдэж арилжаалж эхлээгүй байгаагаас иргэд өөрийн эзэмшлийн хувьцаагаа захиран зарцуулж, эдийн засгийн эргэлтэнд оруулах боломжоор хангагдаагүй байна. Иймд тус компанийг дотоодын хөрөнгийн биржид арилжаалж эхэлснээр гадаадын хөрөнгө оруулагчдыг татах, зах зээлийн хөрвөх чадвар нэмэгдэх зэрэг ач холбогдолтой байна.

6. Хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн найдвартай ажиллагааг хангах

Аливаа зах зээлийн найдвартай байдлыг хангах үндсэн суурь нөхцөл нь техник технологийн аюулгүй ажиллагаа билээ. Олон улсын жишигт нийцсэн Миллениум Ай Ти цогц системийг 2012 оноос хойш хөрөнгийн бирж, арилжааны төлбөр тооцооны байгууллага, үнэт цаасны хадгаламжийн байгууллага болон үнэт цаасны компаниуд зэргээр зах зээлийн хэмжээнд ашиглаж байгаа бөгөөд МХБ системийн зардал, үйлчилгээг дангаараа хариуцаж байна. Уг системийг нэвтрүүлснээр, системийн найдвартай, аюулгүй ажиллагааг бүрэн хангахын зэрэгцээ харилцагчид онлайнаар арилжаанд орох, арилжааны хяналтыг бодит цагийн горимоор хийх, арилжаа болон захиалгын олон шинэ боломжууд, төрлүүдийг зах зээлд нэвтрүүлэх боломжууд бүрдсэн. Энэхүү системийг ашиглаж эхлээд 8 жил өнгөрсөн байгаа бөгөөд энэ хугацаанд зах зээлийн бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдсөн зэрэгтэй уялдуудан хөрөнгийн зах зээлийн технологийн урт хугацааны нэгдсэн бодлогыг тодорхойлох.

Эдгээр арга хэмжээнүүдийг цогцоор нь авч хэрэгжүүлснээр зах зээлд тулгамдаж буй асуудлууд ул суурьтайгаар шийдэгдэж, хөрөнгийн зах зээл цоо шинэ түвшинд хүрч хөгжих боломж бүрдэнэ гэж бид үзэж байна. Ийнхүү хөрөнгийн зах зээл хөгжих нь эдийн засгийг эрчимжүүлэн хөгжүүлэх, компани, бизнесүүд урт хугацааны хямд эх үүсвэрийг татан төвлөрүүлэх боломжтой болох, ард иргэд, олон нийтийн зүгээс хуримтлалаа хамгийн ашигтайгаар байршуулж хөрөнгийн үнэ цэнээ тасралтгүй өсгөхөд онцгой ач холбогдолтой билээ. Иймд хөрөнгийн зах зээлийн эдгээр ач холбогдлыг харгалзан үзэж, зах зээлийн нийт оролцогчдын хэмжээнд уг асуудлуудыг хамтран шийдвэрлэх чиглэлд бүх талын нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлэх, санал солилцох, нэгдсэн байр сууринд хүрэх, хөрөнгийн зах зээлийн урт хугацааны нэгдсэн бодлоготой болох, шийдлүүдийг нэн даруй хэрэгжүүлэх арга хэмжээ авч хамтран ажиллахыг МХБ-ийн зүгээс хөрөнгийн зах зээлийн оролцогчид та бүхэнд УРИАЛЖ байна.

Бидний уриалгыг хүлээн авч хамтдаа хөрөнгийн зах зээлийн хөгжлийн төлөө гар нийлэн ажиллана гэдэгт итгэж байна.



Т+2 ГОРИМЫН ЭХНИЙ ТӨЛБӨР ТООЦОО АМЖИЛТТАЙ ХИЙГДЛЭЭ

Үнэт цаасны зах зээлийн арилжааг идэвхжүүлэх, хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, дэд бүтцийн байгууллагуудын үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэх зорилгоор гаргасан СЗХ-ны 2020 оны 1-р сарын 29-ны өдрийн 29 тоот тогтоол, "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК, "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ТӨХХК, "Арилжааны төлбөр тооцоо ҮЦК" ТӨХХК зэрэг байгууллагуудын 2020 оны 3-р сарын 27-ны өдрийн А25/А10/А31 тоот хамтарсан тушаалын дагуу Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны арилжааны дараах үйл ажиллагааг 2020 оны 3-р сарын 31-ний өдрөөс клирингийн гишүүнчлэл бүхий шинэ үйлчилгээ, төлбөр тооцооны Т+2 горим, төлбөрийн эсрэг нийлүүлэлт (DvP) зарчимд шилжүүлсэн билээ.

Уг горимын дагуу 2020 оны 3-р сарын 31-ний өдөр явагдсан **561,644,042.53** төгрөгийн үнийн дүн бүхий арилжааны төлбөр тооцоо өнөөдөр 11:00 цагт төлбөр тооцооны Т+2 горим, төлбөрийн эсрэг нийлүүлэлт (DvP) зарчмын дагуу амжилттай хийгдэж, 31 төрлийн 1.05 сая ширхэг хувьцааны өмчлөх эрх баталгаажлаа.

"АРИЛЖААНЫ ЖУРАМ"-Д НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРЛОО

"Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 02 дугаар 07-ны өдрийн 2020/07 тоот тогтоолоор баталсан "Арилжааны журам"-ын нэмэлт өөрчлөлтийг СЗХ-ны даргын 2020 оны 3-р сарын 19-ны 123 тоот тушаалаар батламжилсан байна.

Уг нэмэлт өөрчлөлтөөр МХБ-ийн арилжааны хэлцэл баталгаажуулах, хэлцэл цуцлах зэрэг нарийвчилсан зохицуулалтуудыг тусгаснаас гадна хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, сангийн нэгж эрх зэргийг арилжих, тэдгээрийн арилжааны шимтгэл хураамжийн талаар нэмж орууллаа.

ДЭЛХИЙН 85 ХӨРӨНГИЙН БИРЖ ЖЕНДЕРИЙН ТЭГШ БАЙДЛЫН ТӨЛӨӨ ХОНХ ЦОХИЛОО

"Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК /МХБ/ нь гүйцэтгэх болон удирдах түвшний ажлын байранд эмэгтэйчүүдийн оролцоог дэмжиж, жендерийн тэгш байдлыг хангахад анхааран ажилладаг бөгөөд тэгш оролцоог бусад байгууллагуудад уриалах зорилгын хүрээнд Олон Улсын Санхүүгийн Корпораци /ОУСК/, Тогтвортой хөрөнгийн биржүүдийн санаачлага, НҮБ-ын Глобал Компактын Монгол Улс дахь сүлжээ байгууллага, НҮБ-ын Эмэгтэйчүүдийн байгууллага, МҮХАҮТ-ын дэргэдэх Бизнес Эрхлэгч Эмэгтэйчүүдийн зөвлөл зэрэг байгууллагуудтай хамтран **"Жендерийн тэгш байдлын төлөө хонх цохих"** ёслолын арга хэмжээг жил бүрийн "Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр"-ийг тохиолдуулан зохион байгуулж ирсэн уламжлалтай.

Бизнес болон тогтвортой хөгжилд жендерийн тэгш байдлын чухлыг олон нийтэд таниулах зорилготой тус арга хэмжээг энэ жил дэлхийн 85 бирж зохион байгуулж байгаа бөгөөд МХБ нь энэ жил олон улсад тархаад буй COVID-19 вирустай холбоотой онцгой нөхцөл байдлын улмаас тус арга хэмжээг цуцлаад байна.

Жендерийн тэгш оролцоог хангах нь хүний эрх, эрх чөлөөний шударга зарчмыг хэрэгжүүлэхийн зэрэгцээ бизнесүүд, байгууллагууд бүрэн хүчин чадлаа дайчлан ажиллах, ажлын үр дүнг үнэмлэхүй хэмжээнд нэмэгдүүлдэг болох нь дотоод, гадаадын олон судалгаа, практик туршлагаар батлагдсан байдаг. Иймд МХБ-ийн зүгээс жендерийн тэгш оролцоог хангаж ажиллахыг хөрөнгийн зах зээлийн оролцогч бусад байгууллагууд, бүртгэлтэй хувьцаат компаниуд, гишүүн компаниуддаа хандан уриалж байна.



ҮНЭТ ЦААСНЫ КОМПАНИУДЫН АНХААРАЛД

Санхүүгийн хориг арга хэмжээг авч хэрэгжүүлэх олон улсын байгууллага /FATF/-аас 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн хурлаараа Монгол Улсыг стратегийн дутагдалтай орнууд буюу саарал жагсаалтад оруулж, хугацаатай үүрэг даалгаврыг 4 чиглэлээр өгсөн. Өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх чиглэлд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4.1.2-4.1.8-д заасан мэдээлэх үүрэгтэй этгээдэд энэ хуулиар болон Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, хяналт шалгалтыг эрсдэлд суурилсан хэлбэрээр хэрэгжүүлэх, эдгээрийг эрчимжүүлэх ажлууд хийгдэж байна.

Үүнтэй холбоотойгоор эрсдэлд суурилсан хяналт шалгалтад шаардагдах мэдээллийг цуглуулах, дүн шинжилгээ хийх, салбарын мэдлэгийн ерөнхий түвшинг тогтоох, цаашдын сургалтын хөтөлбөрийн агуулга боловсруулах, эрсдэлийг үнэлэх зорилгоор **“Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх эрсдэлийн үнэлгээний асуулга”**-ыг google forum ашиглан явуулж байгаа бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалттай салбарын мэдээлэх үүрэгтэй этгээдүүд бөглөж ирүүлэх шаардлагатай.

Иймд, эрсдэлийн үнэлгээний асуулгыг үнэн зөвөөр, заасан хугацаанд буюу 2020 оны 03 дугаар сарын 27-ны өдөрт багтаан ирүүлж, хамтран ажиллахыг хүсье.

Санхүүгийн зохицуулах хорооноос шаардсан мэдээллийг заасан хугацаанд хүргүүлээгүй, хамтран ажиллахаас татгалзсан тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн 11.29 дүгээр зүйлийн 11 дэх хэсэгт “Мэдээлэх үүрэгтэй этгээдийн хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих зорилгоор баримт, тайлан, мэдээлэл, тайлбар гаргуулан авах талаар хуульд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд саад учруулсан, хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй, биелүүлэхгүй байхыг уриалсан, шаардсан мэдээллийг цаг хугацаанд нь гаргаж өгөөгүй, хөндлөнгөөс нөлөөлөхийг оролдсон нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гучин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэж заасныг үндэслэн хариуцлагын арга хэмжээг авч хэрэгжүүлэх нөхцөл үүсэж болохыг мэдэгдье. ЖИЧ: МУТС эрсдэлийн үнэлгээний асуулгыг дараах холбоосоор татаж авах боломжтой:

1. Үнэт цаасны салбар

[/https://docs.google.com/forms/d/1LWRLiRwBxYzaTu_2WeuD9PrjMKkiMOJY_UZgkH3alX74/edit](https://docs.google.com/forms/d/1LWRLiRwBxYzaTu_2WeuD9PrjMKkiMOJY_UZgkH3alX74/edit)

Түүнчлэн Хорооны цахим хуудсаар үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх тухай асуудал, санхүүгийн зорилтот хориг арга хэмжээний журам аргачлалтай [/http://www.frc.mn/d/s/24/](http://www.frc.mn/d/s/24/) дарж танилцана уу.



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК ИНСТАГРАМ -Д НЭГДЛЭЭ

Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК нь олон нийтийн сүлжээ болох "Инстаграм"-д нэгдлээ. Бидэнтэй үргэж хамт байдаг эрхэм харилцагч та бүхэн бидний Инстаграм хуудсаар зочлоорой!

"ХАР ХОРУМ ПРОПЕРТИЙС" ХК-ИЙН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААГ СЭРГЭЭЛЭЭ

"Хар хорум пропертийс" ХК-ийн үнэт цаасны арилжааг сэргээх тухай Санхүүгийн Зохицуулах Хорооны Улсын байцаагчийн 2020 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 51 тоот албан шаардлагын дагуу арилжааг 2020 оны 3 дугаар сарын 13-ны өдрөөс нээлээ.

Тус компанийн үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахтай холбогдуулан үнэт цаасны арилжааг 2019 оны 1 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн түр зогсоогоод байсан билээ.

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРЭЙШН 2019 ОНЫ ТАЙЛАНГАА ТАНИЛЦУУЛЛАА

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн (TSX:ERD; MSE:ERDN) 2019 оны 12 сарын 31-ээр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, Баян Хөндий Алтны Төслийн хөгжүүлэлтийн мэдээллээс гадна COVID-19 вирустэй холбоотой нөлөөллийн тухай танилцууллаа.

2019 онд Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн нь өнгөрсөн нэг жилийн хугацаанд 2 ордын анхан шатны эдийн засгийн тооцоолол болон Баян Хөндийн урьдчилсан ТЭЗҮ-г боловсруулан танилцуулж, 3.7 г/т дундаж алтны агуулга бүхий 400,000 унц илээр олборлох боломжтой үйлдвэрлэлийн нөөцийг тодорхойлж, 2 ашиглалтын тусгай зөвшөөрөл авч, усны нөөцийг бүртгүүлэн, газар ашиглалтын зөвшөөрөл авсан ба хайгуулын хөтөлбөрөөр ордын нөөцийг нэмэгдүүлсэн байна.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНООС ГАРГАСАН УРИАЛГЫН ХҮРЭЭНД ХУВЬЦААТ КОМПАНИУД ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛАА ЦАХИМ ХЭЛБЭРЭЭР ЯВУУЛАХ ШИЙДВЭР ГАРГААД БАЙНА.

№	Компанийн нэр	Цаг	Өдөр
1	Лэнд МН ББСБ ХК	12:00	2020.03.28
2	Монгол базальт ХК	15:00	2020.04.03
3	АПУ ХК	14:00	2020.04.20
4	Инвескор ББСБ ХХК	14:00	2020.04.09
5	Мах Импекс ХК	14:00	2020.04.24
6	Говь ХК	10:00	2020.04.24
7	Талх Чихэр ХК	14:00	2020.04.20
8	Мандал Даатгал ХК	17:00	2020.04.23
9	Мик Холдинг ХК	11:00	2020.04.30
10	Техник Импорт ХК	10:00	2020.04.24
11	Би Ди Сек ҮЦК ХК	10:00	2020.04.20
12	Түмэн Шувуут ХК	18:00	2020.04.22
13	Монос Хүнс ХК	15:00	2020.04.27
14	Сүү ХК	15:00	2020.04.17



2019 ОНЫ ЦЭВЭР АШГААС ТАРААГДАХ НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Симбол	Компанийн нэр	Нийт хуваарилах ногдол ашиг /сая төгрөг/	Нэгж хувьцаанд олгосон ногдол ашиг /төг/	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр	Хуваарилах хэлбэр
1	ATR	Атар-Өргөө ХК	60.9	350	-	2020.08.01	ҮЦТХТ
2	ADB	Ард кредит ББСБ ХК	1184.6	4.23	2020.04.08	2020.06 дотор	ҮЦТХТ
3	APU	АПУ ХК	75471.2	71	-	2020.08 дотор	ҮЦТХТ
4	TCK	Талх чихэр ХК	230.3	225	-	2020.06.20	ҮЦТХТ
5	AIC	Ард даатгал ХК	850	34	2020.04.09	2020.06 дотор	ҮЦТХТ
6	MBW	Монгол базальт ХК	255.6	4	2020.03.09	2020.06 дотор	ҮЦТХТ
7	BDS	Би ди сек ХК	136.9	10	2020.03.09	2020.12 дотор	ҮЦТХТ
8	NEH	Дархан нэхий ХК	232.1	210	2020.02.25	2020.09 хойш	ҮЦТХТ
9	LEND	ЛэндМН ББСБ ХК	1200	1.5	2020.02.25	2020.04 дотор	ҮЦТХТ
10	MNP	Монгол шуудан ХК	331	3.3	-	2020.05.01-с	ҮЦТХТ
11	HRD	Хүрд ХК	72.3	535	2020.03.02	2020.06 дотор	ҮЦТХТ
12	HRM	Гермес центр ХК	322	4.1	2020.02.28	2020.03.15	ҮЦТХТ
13	BUK	УБ-бүк ХК	526.2	4	-	2020.06.01	ҮЦТХТ
14	UBH	УБ хивс ХК	121.4	300	2020.03.06	2020.05.01-с	ҮЦТХТ
15	TAH	Тахь-ко ХК	128.5	108	-	2020.04 дотор	ҮЦТХТ
16	AARD	Ард санхүүгийн нэгдэл ХК	1000	34.95	2020.04.07	2020.04 дотор	ҮЦТХТ
17	MNDL	Мандал даатгал ХК	2490	4	-	2020.06 дотор	ҮЦТХТ
18	BNG	Баянгол ЗБ ХК	152.3	360	-	2020.09.01-с	ҮЦТХТ
19	MMX	Мах импекс ХК	456	120	-	2020.10.01-с	ҮЦТХТ
20	JTB	Женко тур бюро ХК	799.8	10	-	-	ҮЦТХТ
21	TEX	Техник импорт ХК	723.3	500	2020.03.11	2020.04.24-с	Компанийн байран дээр
22	MFC	Монос хүнс ХК	408.8	1	-	2020.08.31-с	ҮЦТХТ
23	MCH	Монголын цахилгаан холбоо ХК	25.8	1	-	2020.06.01-с	ҮЦТХТ
24	HUV	Хөвсгөл геологи ХК	21.5	150	2020.04.03	2020.05.01-с	ҮЦТХТ
25	GTL	Гутал ХК	2403.6	1520	2020.03.13	2020.05.05-с	ҮЦТХТ
26	HZB	Ган Хэрлэн ХК	14.9	150	2020.03.18	2020.09.30 дотор	ҮЦТХТ
27	BTG	Баян тээг ХК	500	1979.3	2020.04.07	2020.12.01 дотор	ҮЦТХТ
28	SUU	Сүү ХК	1715.1	5	2020.03.27	2020.05.01-12.31	
29	EER	Ариг гал ХК	32.49	109.4	2020.03.27	2020.06.30 дотор	ҮЦТХТ
30	TUM	Түмэн шувуут ХК	4.80	3200	2020.04.07	2020.06.24	ҮЦТХТ
31	DSS	Дархан сэлэнгийн цахилгаан түгээх ХК	37.73	391.8	2020.03.20	2020.09.02	ҮЦТХТ



МОНОС ХҮНС ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Монос хүнс ХК нь шинэ төрлийн короновирусний /COVID-19/ болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх үүднээс Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2020 оны 04 сарын 27 өдрийн 15 цагаас цахим хэлбэрээр хуралдуулахаар боллоо.

Хуралд оролцох алхам

- 1 2020.04.10-2020.04.24 ажлын өдрүүдэд 09:00-16:00 цагийн хооронд "Монос Хүнс" ХК-ийн Мишээл экспо худалдааны төвийн баруун талд байрлах хуурай хүнсний үйлдвэрийн байранд өөрийн биеэр /итгэмжлэгдсэн төлөөлөгч/ иргэний үнэмлэхний хамт ирж бүртгүүлнэ.
- 2 2020 оны 4 сарын 27-ны өдөр цахимаар хийх Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдэд "цахим хаягийн холбоос, нэвтрэх нэр, нууц үг" зэргийг олгоно. (ХЭХ болох өдрөөс өмнө холбоосоор нэвтрэх боломжгүй)
- 3 2020 оны 4 сарын 27-ны өдөр 10:00 цагаас эхлэн цахим холбоосоор нэвтрэх боломж нээгдэх ба хувьцаа эзэмшигч та нэвтрэх нэр, нууц үгээ ашиглан нэвтрэх компанийн тайлан, танилцуулга, хурлын дэгтэй танилцах, урьдчилан санал өгөх эрх зэрэг нь нээлттэй болно.
- 4 Цахим хурлын үйл ажиллагаа 2020.04.27 өдрийн 15:00 цагаас эхэлнэ.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг 99035178, 88080308 утсаар холбогдон авна уу.

ХҮҮХЭД БАГАЧУУДЫН ДУРТАЙ ААМИ, ТААМИ УНДАА ХЭРЭГЛЭХЭД ИЛҮҮ ХЯЛБАР БОЛЛОО

Үндэсний контентийг дэмжих зорилгоор Монос Хүнс компани нь Монгол Контент компанийн "Маамуу" брэндтэй хамтран ажиллаад багагүй хугацааг өнгөрүүлжээ. Энэ хугацаанд бид хүүхэд багачуудын дуртай Аами, Таами нэрийн ундаа болон үзэмтэй үрлийг бяцхан хэрэглэгчиддээ зориулан үйлдвэрлэж байна. Өнгөрсөн 2-р сард Монос Хүнс ХК-ийн эрүүл мэндийн шингэн хүнсний үйлдвэр ашиглалтад орж, Аами, Таами брэндийн ундаа шинэ үйлдвэрээс шинэхэн савлагаатайгаар худалдаанд гарлаа. Энэхүү савлагаа нь олон улсын стандартад нийцсэн, хүүхэд уухад хялбар, барихад эвтэйхэн бөгөөд машинд уухад, аялал зугаалгын үед хэрэглэхэд тохиромжтой юм. Шинэчлэгдсэн савлагаа бүхий Аами ундаа нь аньс, гүзээлзгэнэ, Таами ундаа нь лууван, чацарганын цэвэр шүүсийг агуулдаг учраас таны хүүхдийг хэрэгцээт аминдэмээр хангахаас гадна хүүхдийн хүнс тэжээлээр нэг өдөрт авбал зохих витамин С-н хэрэглээг бүрэн хангана. Тиймээс хайртай үрсийг тань ханиад томуунаас урьдчилан сэргийлж, дархлааг сайжруулах, хүүхдийн өсөлтийг дэмжих зэрэг давуу талтай.



Өнгөлөг өхөөрдөм дизайнаас нь эхлээд хүүхдийн шингэн уух хүслийг нэмэгдүүлэх Аами, Таами нэрийн ундаагаа Монос эмийн сангийн салбарууд болон өөрт ойр байрлах сүлжээ дэлгүүрээс худалдан аваарай. Мөн emonos.mn, avlaa.mn сайтаар захиалан гэртээ хүргүүлэх боломжтой.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ



Монгол Улс, Улаанбаатар
хот 15160

Сүхбаатарын талбай-3

Монголын Хөрөнгийн Бирж



+976 11-313747



+976 11-325170



Info@mse.mn



WWW.MSE.MN